

ЭРҮҮЛ МЭНДИЙН СЭДВИЙГ МОНГОЛЫН ӨДӨР ТУТМЫН СОНИНД ТУСГАЖ БАЙГАА НЬ

Д.Ариунцэцэг*

* Сэтгүүл зүйн магистр, докторант

Түлхүүр үг: эрүүл мэндийн сэтгүүл зүй, эрүүл мэндийн үндсэн сэдвүүд, эрүүл мэндийн сэдвийг тусгаж буй арга хэлбэр, эх сурвалжийн төвшин

Сэтгүүл зүй эмчийн нэгэн адил амьдралын судсыг барьж, нийгэмд онош тавихын хамт шаардлагатай гэж үзвэл "эмчлэх" эмчилгээний стратеги, тактикийг тодорхойлдог¹. Эмч чагнуур барьж хүнийг эмчилдэг бол сэтгүүлч үг урлаж нийгмийг эмчилдэг. Тэр ч утгаараа энэ хоёр мэргэжил хүний сайн сайхны төлөө зорилго нэгддэг буянтай ажил билээ.

"Анагаах ухаан сэтгүүл зүйд бусад мэргэжлээс илүү ойрхон, хүйн холбоотой байж магадгүй. Учир нь эмч хүн үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл зүйг судална, сэтгүүлчид хүмүүсийг судална. Энэ онцлог нь тэднийг бусдаас илүү ажигч гярхай агаад мэдрэмтгий болгодог байж мэднэ. Антон Павлович Чехов эмч байсан. Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнэ мөн л эмч байсан. Монголын анагаах ухаан Т.Очирхүү, С.Оюун, Ш.Ванчаарай, Ц.Мухар зэрэг уран үгийн цөөнгүй мастерыг Монголын утга зохиол, сэтгүүл зүйд шилжүүлэн өгсөн түүхтэй"² гэж сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн онцлон тэмдэглэжээ.

Эрүүл мэнд, өвчин эмгэг, эрүүлийг хамгаалах салбар болон эм, бэлдмэл-

лийн сэдвийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тусгайлан хөндөж, олон нийтэд хүргэх зорилго бүхий сэтгүүлчийн үйл ажиллагааг эрүүл мэндийн (Health journalism reporting), анагаах ухааны (Medical journalism reporting) сэтгүүл зүйн аль алинаар нь нэрлэдэг ч анагаах ухааны сэтгүүл зүй гэсэн нэр томьёог ашиглах нь олон улсад түгээмэл байдаг.

Тусгай нэр томьёо, шинжлэх ухаан, түүний дотор анагаах ухааны мэргэжлийн хэллэг ихээхэн ашигладаг болохоор эрүүл мэндийн сэтгүүл зүйг шинжлэх ухааны сэтгүүл зүйн (Science journalism reporting) бүрэлдэхүүн хэсэг ч гэж үздэг байна.

Эрүүл мэндийн сэтгүүл зүйг маш энгийнээр ОНМХ-ээр дамжуулан иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл явц гэж ойлгож болно. Өргөн утгаараа эрүүл мэндтэй холбоотой нийгмийн бүх харилцааг (улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, шашин, хууль эрх зүй гэх мэт) ОНМХ-ээр дамжуулан зохицуулах үйл ажиллагааг эрүүл мэндийн сэтгүүл зүй гэнэ. Мөн түүнийг глобал ба улс орны шинж чанартай эрүүл мэндийн зэрэг ба сөрөг асуудлуудыг тасралтгүй тусгах үйл явц ч гэж ойлгож болох юм.

Мэдээллийн асар хүчтэй урсгал дундах өнөөгийн нийгэмд олон нийт өөрт хэрэгтэй мэдээллээ олж авах нь

чамгүй цаг зав шаардсан ажлын нэг юм. Энэ ажлыг хөнгөвчлөхөд 1913 оноос түүхэн улбаатай тогтмол хэвлэл өнөөдөр ч багагүй үүрэг гүйцэтгэсээр байна. Үүн дотор нийгмийн олон талт мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэдэг өдөр тутмын сонин чухал байр эзэлдэг. Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн асуудлыг өдөр тутмын сонинууд тодорхой хэмжээгээр тусгаж, энэ чиглэлээр голлон бичдэг сэтгүүлчид бий болжээ. Тухайлбал “Үндэсний шуудан” сонин 7 хоногийн баасан гаригийн дугаарынхаа арын нүүрэнд “Болдсайхан эмчийн булан”-г тогтмол явуулдаг бол “Ардын эрх” сонин 7 хоног бүрийн пүрэв гаригийн дугаарынхаа 5-р нүүрийг эрүүл мэндийн сэдэвт зориулдаг байна. Түүнчлэн “Нийгмийн толь” сонин 14 хоногт нэг удаа “Эрүүл мэнд” малгай гарчгийн дор багц зөвлөгөө мэдээлэлд бүтэн нүүрний зай талбай өгдөг бол, “Монголын мэдээ”, “Өглөө-

ний сонин”, “Өнөөдрийн монгол” зэрэг бусад сонинд 7-14 хоногт эрүүл мэндийн сэдвийг их бага хэмжээгээр тусгаж байна.

Энэхүү судалгаанд манай орны өдөр тутмын нөлөө бүхий гурван сониныг төлөөлүүлэн авч үзэв. Өөрөөр хэлбэл “Өдрийн сонин” (7 хоногт 9365 ш)-ы 2009 оны 9 сараас 2010 оны 4 сар хүртэлх хагас жилийн дугаар, “Өнөөдөр” (7 хоногт 6430 ш) болон “Зууны мэдээ” (7 хоногт 5840 ш) сонины 2009 оны 3 ба 4-р улирлын дугаарыг судалгааны эргэлтэнд оруулж, эрүүл мэндийн сэдэвт нийтлэлд нь ажиглалт хийлээ. Ингэхдээ сонины зай талбайд эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн эзлэх хувь, сэдвийн ангилал, нийтлэлийн зорилго, эх сурвалжийн төвшин, бичлэгийн төрөл зүйл, өнгө аяс, нийтлэлийн уншигчдын ангилал гэсэн чиглэлээр судалгаа хийсэн болно.

Сонины зай талбайд эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн эзлэх хувь

Хүснэгт №1

№	Сонины нэр	Улиралд гарсан нийт дугаар	Эрүүл мэндийн сэдэвт нийтлэл гарсан дугаар	Эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн эзлэх хувь	Тайлбар
1	“Өдрийн сонин”	72	21	0.73%	
2	“Өнөөдөр”	72	33	1.06%	Тус сонины судалгаанд хамрагдсан дугааруудын хугацаа гахайн томууны ид дэгдэлтийн үетэй давхацсан тул эзлэх хувь бусдаасаа илүү гарсан.
3	“Зууны мэдээ”	72	12	0.77%	Гарсан дугаар нь “Өдрийн сонин”-той харьцуулахад цөөн боловч эзлэх хувь нь илүү байсан нь нэг талаас эрүүл мэндийн сэдэвт нийтлэлд дугаар бүртээ бүтэн нүүр зориулдаг, нөгөө талаас харьцуулсан сониныг бодвол цөөн нүүрээр гардагтай холбоотой.
	Дундаж	72	22	0.85%	

Судалгааны дундаж үзүүлэлт 0.85% байгаагаас харахад өдөр тутмын эдгээр сонин эрүүл мэндийн сэдэвт зориулах зай талбайд туйлын харам ханддаг байна. Үүнийг нэг талаар тэдгээр сонины нийтлэлийн бодлогод улс төрийн асуудал давамгайлсантай, нөгөө талаар эрүүл мэндийн биеэ даасан алба байдаггүйтэй холбон үзэж болно. Өөрөөр хэлбэл өдөр тутмын сонинууд эрүүл мэндийн сэдвийг урсгал шинжтэй тусгадаг нь харагдаж байна. Дурдсан сонинуудад энэ сэдвээр бичдэг сэтгүүлчид нийгэм соёл, гадаад мэдээний, эсвэл нийгэм эдийн засгийн албанд харьяалагддаг. Тэд цаг зав маш бага байдаг тул тэр бүр даацтай материал нийтэлж чаддаггүй, үндсэн сэдвийнхээ зав чөлөөнөөр эрүүл мэндийн материал бичдэг байна.

Хэдийгээр эрүүл мэндийн сэтгүүл зүйг эрүүл мэндийн дагнасан сонин, сэтгүүл нь авч явна, хөгжүүлнэ гээд орхиж болох ч хамгийн олон хүнд

хүрдэг, хүртээмжтэй, олон түмний итгэл үнэмшилд нөлөөлөх чадвар өндөр гэдэг утгаараа өдөр тутмын хэвлэлүүд сэтгүүл зүйн энэ чиглэлд даацтай үүрэг гүйцэтгэх учиртай. Энэ талаар сэтгүүлч С.Отгонцэцэг "...өдөр тутмын сонин эрүүл мэндийн асуудалд долоо хоногт нэг л нүүрээ зориулж, үүндээ энэ салбарын аль нэг албаны өдрөөр нүүр дүүрэн сурталчилгаа, "Алтан хүн" гэх мэтийн хувийн эмнэлгийн төлбөртэй нийтлэл, мөнгөжүүлсэн ус, тайвшруулагч зүүлт мэтийн реклам, эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг ТББ-уудын тайлан, судалгаа хэлбэрийн далд сурталчилгаа, хоолны болон усны хуванцар сав, шүдний чигчлүүр, мөнгөний дэвсгэртийн өвчин үүсгэх, тараах магадлалын тухай анхааруулга, сэрэмжлүүлэг, зөвөлгөө, асуулт хариулт голдуу материал нийтэлж байгаа нь улс төр, эдийн засаг, гэмт хэрэг зэрэг сэдвүүдтэй харьцуулахад үнэхээр байгаа юм"³ хэмээн тэмдэглэжээ.

Эрүүл мэндийн нийтлэлийн сэдэв

Хүснэгт №2

№	Сэдэв	Өдрийн сонин	Өнөөдөр	Зууны мэдээ	Дундаж үзүүлэлт
1	Өдөр тутмын эрүүл ахуйн	1.75%	4%	0%	1.9%
2	Эмэгтэйчүүд, нөхөн үржихүй	3.5%	4%	16%	7.8%
3	БЗХӨ, ДОХ	1.95%	6%	0%	2.6%
4	Мал, амьтны гаралтай халдварт өвчин	0%	32%	10.5%	14.2%
5	Эмч, эм, эмчилгээ, эмнэлэг	42.1%	28%	47.3%	39.1%
6	Эрүүл мэндийн салбартай холбоотой (хөгжил, тулгамдсан асуудал, хариуцлага, алдаа дутагдал, боловсон хүчин, авлигал)	31.6%	26%	0%	19.4%
7	Ардын уламжлалт эм, эмчилгээ	5.2%	0%	0%	1.7%
8	Танин мэдэхүй (шинэ нээлт, туршилт, эмчилгээ)	5.2%	0%	5.2%	1.7%
9	Хандив тусламж хүссэн	0%	0%	15.8%	5.3%
10	Эрүүл хоол, тэжээл	3.5%	0%	0%	2.9%
11	Экологитой холбосон	5.2%	0%	0%	1.7%
12	Бусад	0%	0%	5.2%	1.7%

Судалгаагаар сонинууд дахь эрүүл мэндийн нийтлэл нь янз бүрийн сэдвийг тусгасан ч үүн дунд зонхилох

байр суурьтай хэд хэдэн сэдэв байна. Хүснэгтээс үзэхэд хамгийн өндөр хувьтай нь эм, эмчилгээний холбогдолтой

сэдэв байсан бол үүний дараагаар 19.4%-иар эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай холбоотой сэдэв оржээ. Харин дээрх гурван сонин өдөр тутмын эрүүл ахуй, эрүүл хоол хүнсний, шинэ нээлт, туршилт ололт амжилтын тухай маш бага бичдэг нь харагдаж байна. Түүнчлэн элэг, зүрх, бөөр, цөс, харшил зэрэг нийтлэг өвчний тухай л байхаас биш тэр бүр хүмүүс мэддэггүй ч сүүлийн үед түгээмэл тархсан нүдний ханиад, ходоодны хеликобактер зэрэг зарим нэг өвчний тухай цөөн хөнджээ. Харин "Өдрийн сонин"-д нийтлэгдсэн Т.Гэрэлмаагийн "Глаукомоор өвдсөн хүн сохрох аюултай" (2010.03.12, №060), "Дауны хам шинж гэдэг бол өвчин биш"

(2010.03.23, №069) зэрэг гарчигтай материал "ховор" сэдвийг хөндснөөрөө өгөөжтэй болжээ. Сонинуудад нийтлэг ажиглагдсан өөр нэг зүйл нь "Өдрийн сонин"-д нийтлэгдсэн "Улаанбаатар их сургуулийн профессор жоншноос нанотехнологийн аргаар эмийн бэлдмэл гарган авчээ" (Л.Батцэнгэл, 2009.09.28, №234) ярилцлагыг эс тооцвол шинжлэх ухаан танин мэдэхүйн, тайлбарласан, хялбаршуулсан жинтэй материал нийтлэхэд маш бага анхаардаг нь харагдаж байна. Үүнийг сэтгүүлч бие даан бичихэд хүндрэлтэй хэдий ч мэргэжлийн хүнээр нь бичүүлэх, эсвэл тийм эх сурвалжтай ярилцлага хийх гэхчилэн янз бүрийн боломж бий.

Энэ сэдвийг тусгасан нийтлэлийн зорилго

Хүснэгт №3

№	Зорилго	"Өдрийн сонин"	"Өнөөдөр"	"Зууны мэдээ"	Дундаж үзүүлэлт
1	Эрүүл мэндийн салбарын дутагдал доголдлыг арилгах, олны анхаарлыг хандуулах	38.6%	28%	26.3%	31%
2	Өвчин, эм эмчилгээний ерөнхий мэдээлэл өгөх	43.8%	56%	68.4%	56%
3	Урдчилан сэргийлэх	7%	6%	0%	4.3%
4	Далд суртчилах	8.8%	6%	0%	4.9%
5	Танин мэдүүлэх	1.8%	2%	5.3%	3%
6	Тодорхой бус	0%	2%	0%	0.6%

Эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн зорилгыг авч үзвэл гурван сонинд нийтлэг хандлага ажиглагдаж байна. Тэд ихэнхдээ аливаа өвчин, эм эмчилгээний талаарх ерөнхий ойлголт, мэдээллийг нийтэлж, мөн эрүүл мэндийн салбар дахь дутагдал доголдлын шүүмжлэл бүхий материалд анхаарлаа түлхүү хандуулсан байна. Харин эрүүл мэндийн салбарын шинэ мэдлэг мэдээлэл хүргэж, аливаа өвчлөлөөс урдчилан сэргийлэх арга замыг зааж өгсөн нь цөөн, харин ямар нэг эм, эмчилгээний талаарх, итгэл үнэмшил төрүүлэх зорилготой далд сурталчилгааны материалд багагүй зай талбай

зориулжээ. Харин "Зууны мэдээ" сонины хувьд асуудал хөндсөн дорвитой материал цөөн байсан боловч далд сурталчилгааны шинжтэй материал огт ороогүй байсныг дурдах нь зүйтэй.

Эрүүл мэндийн салбар дахь дутагдал доголдлыг арилгах, олны анхаарал татахыг зорьсон нийтлэлийн жишээнд "Өдрийн сонин"-ы Б.Батцэцэгийн "Хүний амь таван эмчийн ажлын байрнаас хямд болжээ" (2009.12.12, №298), М. Мөнхцэцэгийн "Эмч нарын хайхрамжгүйгээс зургаахан хоногтой нярай энджээ" (2009.12.16, №301), Олхонууд Шаабарын "Эрүүл мэндээр арилжаа хийгээд байна уу" (2010.01.12, №008),

"Өнөөдөр" сонины Ц.Энхмаагийн "Өвчтэй монгол" (2009.10.14, №236), Б.Элдэвийн "Масктай Монгол" (2009.11.06, №257), Р.Оюунгэрэлийн "Эрүүл хүн заалнаас эхэлдэг" (2009.12.03, №278), "Зууны мэдээ" сонины Ж.Жаргалын "Дархлаагүй дархлаажилт" (2009.08.25, №197) зэрэг нийтлэлийг дурдаж болно. Харин "Өнөөдөр" сонинд "Түгшүүр дэгдэхэд түшмэд зоолно" (Р.Эмүжин, 2009.12.08, №282), "Содон үйл явдал" дэд гарчгийн дор нийтлэгдсэн "Масктай Монгол" (Б.Элдэв, 2009.11.06, №257), "Гахайн ханиад ЭМЯ-ны тендерт шалгарсан бололтой" (2009.10.17, №239) зэрэг өгүүлэл хошин өнгө аясаар бичигдсэн, зохиомжийн өвөрмөц шийдэлтэй ч зарим талаар зохиогчийн хувийн үзэл бодол, хэтрүүлэл оржээ.

Түүнчлэн ямар нэг эм бэлдмэл, эмчилгээ, эмнэлгийн тухай далд сурталчилгааны шинжтэй материал ч цөөнгүй байгаатай таарлаа. Ялангуяа "Өдрийн сонин"-д ийм шинжтэй материал элбэг байгаа нь "Энэ тухай", "Таны сонорт" малгай гарчгийн дор нийтлэгдсэн "Ачит эх" эмнэлэг бүх төрлийн өвчнийг дорно дахины уламжлалт эмчилгээгээр анагаадаг" (2009.10.14, №248), "Улаанбаатар Сонгдо эмнэлэг шүдний имплантын эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн" (2009.12.07, №293) зэрэг хэд хэдэн нийтлэлээс харж болно.

Эх сурвалжийг гарал, хангалттай эсэх, дурдсан эсэх гэсэн гурван үзүүлэлтээр авч үзсэн болно.

Эх сурвалж

Хүснэгт №4

№	Эх сурвалжийн шинж байдал	"Өдрийн сонин"	"Өнөөдөр"	"Зууны мэдээ"	Дундаж үзүүлэлт
1	Дотоод	87.7%	94%	89.5%	90.4%
	Гадаад	10.5%	6%	5.25%	7.25%
	Тодорхойгүй	1.8%	0%	5.25%	2.35%
2	Хангалттай	80.7%	80%	84.2%	81.6%
	Хангалтгүй	19.3%	20%	15.8%	18.4%
3	Дурдсан	78.9%	84%	84.2%	82.4%
	Дурдаагүй	21.1%	16%	15.8%	17.6%

Судалгаанаас үзэхэд эх сурвалжийн гарлын хувьд дийлэнх нь дотоод буюу өөрийн орны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, салбарын байгууллагын статистик тоо баримтууд эзэлж байна. Гадаад эх сурвалж маш бага байгаа нь уншигчдад энэ чиглэлийн мэдээллийг харьцуулах, илүү өргөн мэдлэг олж авах боломжийг багасгаж байгаа юм. Эх сурвалж хангалттай эсэх асуудалд тоо болон чанарын төвшинд авч үзэх шаардлагатай ч сэтгүүл зүйд эх сурвалжийн чанарын төвшинг илүүд үздэг. Энэ утгаараа дээрх өдөр тутмын сонинууд дахь эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн эх сурвалж хангалттай гэж

судалгаагаар гарч байна. Гэхдээ эх сурвалж хангалттайн зэрэгцээ баттай байх нь эрүүл мэндийн сэдэвт нийтлэлд амин чухал. АНУ-ын Мэрилэндийн их сургуулийн сэтгүүл зүйн профессор Кэрл Рокерс тусгай буюу эрүүл мэндийн сэдвээр бичдэг сурвалжлагчдад хоёр төрлийн ашигтай зөвлөмж өгсний нэг нь иш татаж буй эх сурвалжийг тодорхой танилцуулах явдал аж. Энэ нь уншигчийн итгэл үнэмшилд сайнаар нөлөөдөг байна. Судалгаанаас ажиглахад дийлэнх нь ярилцлага хэлбэрээр бичигдсэн байгаа тул оршил хэсэгт тийм сэдвийн талаар ийм ажил албатай хүнтэй уулзлаа гэхчилэн эх

сурвалжаа тодорхой хэлсэн байна. Тиймээс цөөн тооны орчуулгын материал, ямар нэг асуудал хөндсөн, эрэн

сурвалжлах шинжтэй нийтлэлээс бусад тохиолдолд эх сурвалжаа нээлттэй дурджээ.

Эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн бичлэгийн ямар төрөл зүйл

Хүснэгт №5

№	Бичлэгийн төрөл зүйл	“Өдрийн сонин”	“Өнөөдөр”	“Зууны мэдээ”	Дундаж үзүүлэлт
1	Ярилцлага				
2	Өгүүлэл	40.5%	12%	31.6%	28%
3	Сурвалжлага	17.5%	12%	10.5%	13.3%
4	Мэдээ	19.3%	8%	15.8%	14.5%
5	Тодруулга	19.3%	66%	26.3%	37.2%
6	Тэмдэглэл	1.7%	2%	10.5%	4.7%
7	Хөрөг	-	-	5.3%	1.7%
		1.7%	-	-	0.6%

Дээрх үзүүлэлтээс энэ сэдвийг голлон мэдээ, ярилцлага, сурвалжлага зэрэг мэдээлсэн бичлэгийн төрлөөр бичсэн болох нь харагдаж байна. Энэ нь 1990-ээд оноос хойш ОНМХ-ийн бичлэгийн төрөл зүйлээс хөрөг, найруулал, тэмдэглэл зэрэг уран сайхны өнгө аяс бүхий бичлэгийн төрөл зүйл шахагдан гарч, харин мэдээ, сурвалжлага, ярилцлага зэрэг мэдээлсэн бичлэгийн төрөл түрэн орж ирсэнтэй нэг талаар холбоотой. Нөгөө талаар янз бүрийн үзэл бодол, уянгын халил, уран сайхны дүрслэл үл тохирох эрүүл мэндийн сэтгүүл зүйн сэдвийн онцлог ч бас үүнд тодорхой нөлөөлсөн байна. Тодруулбал, бичлэгийн төрөл зүйл хязгаарлагдмал байх нь эрүүл мэндийн сэтгүүл зүйн бас нэг онцлог шинж ч гэж болно.

Ярилцлага нь эрүүл мэндийн сэдэвт материал бичихэд хамгийн үндсэн эх сурвалж болдог утгаараа нийт бичлэгийн төрлөөс илүү жин дарж байхад баримт үйл явдлыг олон талаас нь шинжлэн дүгнэж, аливаа асуудлыг хөнддөг өгүүлэл ч зохих хувийг эзэл-

жээ. Үйл явдлын хөгжил, хөдөлгөөн, өрнөл дунд нь дүрсэлж, зохиогчийн идэвхтэй байр сууринаас бичигддэг сурвалжлага мөн эрүүл мэндийн сэдвийг тусгах чухал арга хэрэгсэл болсон байна. Бүх зүйлийг ил тод, товч тодорхой, шуурхай хүргэдэг мэдээний эзлэх хувь хамгийн өндөр гарчээ.

Ярилцлага бол хэвлэл мэдээллийн бүх ажилтны хувьд мэдээллийн гол эх сурвалж юм. Өгүүлэл нь сэтгүүл зүйн сугалаа юм. Түүгээр хүмүүсийг уйлтал, инээтэл, жигштэл бичиж болох тул задлан шинжилсэн, асуудал хөндсөн, шүүмжилсэн даацтай нийтлэлд сэтгүүлч энэ арга хэлбэрийг сонгодог. Мэдээ нь хүмүүст мэдээлэл хүргэдэг бол өгүүлэл тэдэнд таашаал өгдөг. Сурвалжлага бол “Бүх зүйлийн үндэс, цөм” гэж зохиогч Том Вульф хэлжээ⁴. Дээрх тайлбаруудаас үзвэл эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийг мэдээ, сурвалжлага, ярилцлага, өгүүлэл зэрэг бичлэгийн төрөл зүйлээр олон нийтэд хүргэх нь илүү зохимжтой юм.

Эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн үр нөлөө

Хүснэгт №6

№	Бичлэгийн өнгө аяс	“Өдрийн сонин”	“Өнөөдөр”	“Зууны мэдээ”	Дундаж үзүүлэлт
1	Ерөнхий мэдээлсэн	35%	54%	42.2%	43.7%
2	Зөвлөсөн	15.8%	6%	21%	14.3%
3	Сануулж, сэрэмжлүүлсэн	5.2%	2%	10.5%	5.9%
4	Айлган түгшээсэн	12.3%	8%	10.5%	10.3%
5	Жигшээн зэвүүцүүлсэн	15.8%	18%	0%	11.3%
6	Хэт итгэл үнэмшил төрүүлсэн	5.2%	4%	0%	3%
7	Боломж гарц нээсэн	8.8%	8%	0%	5.6%
8	Сэтгэл эмзэглүүсэн	1.9%	0%	15.8%	5.9%

Сонинуудад нийтэлсэн эрүүл мэндийн сэдэвт материалын бичлэгийн голлох өнгө аясыг ажвал ерөнхий мэдээлсэн тал нь давамгайлсан бол үүний дараа зөвлөсөн, жигшээн зэвүү-

цүүлсэн, айлган түгшээсэн материал орсон байна. Мөн дээр хүснэгтээс үзэхэд сануулж сэрэмжлүүлсэн, боломж гарцыг нээсэн нийтлэлд сонинууд бага анхаарчээ.

Эрүүл мэндийн сэдэвт нийтлэлийн хүлээн авагчийн онцлог

Хүснэгт №7

№	Хэнд хандсан	“Өдрийн сонин”	“Өнөөдөр”	“Зууны мэдээ”	Дундаж үзүүлэлт
1	Олон нийт	78.9%	78%	63.3%	73.4%
2	Мэргэжлийн бүлэг	10.5%	14%	10.5%	11.6%
3	Эрэгтэйчүүд	1.75%	2%	5.2%	3%
4	Эмэгтэйчүүд	3.5%	2%	15.8%	7.1%
5	Хүүхэд	1.75%	2%	5.2%	3%
6	Өндөр настнууд	3.6%	2%	0%	1.9%

Судалгаанд хамрагдсан сонинууд дахь эрүүл мэндийн сэдэвт нийтлэл ихэвчлэн олон нийтэд зориулагдсан байна. Мөн мэргэжлийн бүлгийнхэнд хандаж мэдээлэл өгсөн, засаж сайжруулахыг анхааруулсан, шүүмжилсэн нийтлэл 11.6%-ийг эзэлсэн бол эмэгтэйчүүдэд зориулсан материал 7.1%-тай гарсан байна. Харин өндөр настнууд, хүүхдүүд, эрэгтэйчүүдэд хандсан эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээ мэдээлэл туйлын бага байгаа нь ажиглагдлаа.

Дүгнэлт

Өнөөдөр эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн сонин сэтгүүлүүд биеэ даан

хөгжиж, телевиз радиогийн эфирт энэ сэдэвт нэвтрүүлэг тодорхой хэмжээгээр үзэгдэж, өдөр тутмын сонин хэвлэлүүдийн хуудаснаа эрүүл мэндийн нүүр, булан хэвлэгдэн гарч байгаагаас үзвэл эрүүл мэндийн сэтгүүл зүй хэмээх судалгааны энэ чиглэлд шинэ хуудас нээж болохоор байна. Сэтгүүл зүйн энэ чиглэлийг судалгааны эргэлтэнд оруулж, шинэлэг санаа оноогоор баяжуулах шаардлага тавигдаж байгаа юм. Тиймээс аливаа шинжлэх ухааны хөгжил зөв замаараа явахад түүний сургалт, судалгаа маш чухал үүрэг гүйцэтгэдэгчлэн эрүүл мэндийн сэтгүүл зүйд ч дээрх ажлыг эрчимжүүлэх нь чухал юм.

Туйлын хариуцлагатай, энгийн ойлгомжтой, хүнлэг энэрэнгүй, үнэ цэнэтэй, олон талт, шинжлэх ухаанч, танин мэдэхүйн онцлог шинжүүд бүхий энэ сэтгүүл зүйн хамгийн гол зорилго нь үнэн бодит мэдээллийг энгийн ойлгомжтой байдлаар шуурхай хүргэж, олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, улмаар урдчилан сэргийлэхэд чиглэсэн эрүүл мэндийн сайн тогтолцоог бий оршдог гэж үзэж болно.

Дээрх судалгаанаас дараах дүгнэлтэнд хүрлээ:

- Эрүүл мэндийн сэдэвт нийтлэлд зориулах зай талбай (дунджаар 0.85%) бага байна.

- Эрүүл мэндийн сэдэв сонины нийтлэлийн бодлогод урсгал шинжтэй байна.

- Шинжлэх ухаан танин мэдэхүй, өдөр тутмын эрүүл ахуй, амьдралын зөв дадал хэвшил, эмгүй эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, хөдөлгөөний ач тус, эрүүл хооллолтын тухай сэдэв бараг орхигдсон гэж болохоор байна.

- Эрүүл мэндийн салбарын алдаа, доголдолд олны анхаарлыг хандуулах, өвчин, эм эмчилгээний ерөнхий мэдээлэл өгөхийг илүү зорьсноос бус урьдчилан сэргийлэх шинжтэй нийтлэл бага байна.

- Хэдийгээр мэдээллийн эх сурвалжийн хувьд хангалттай байгаа ч дийлэнх хувь нь дотоодын гаралтай байгаа бөгөөд гадаад эх сурвалжаас авах, орчуулгын материал оруулах (оруулсан тохиолдолд эх сурвалжаа дурдах нь ховор), гадаад ертөнц, дэлхийн бусад улс орнуудын мэдээлэл өгөхөд дутуу анхаарч байна.

- Энэ сэдэвт нийтлэл мэдээ, ярилцлага, сурвалжлага гэсэн мэдээлсэн бичлэгийн төрөл зүйлээр голлон бичигдсэн байна.

- Бичлэгийн өнгө аясын хувьд сануулж сэрэмжлүүлсэн, боломж гарц нээсэн, учир байдлыг тунгаасан шинж хангалтгүй оржээ.

- Ихэнх нийтлэл олон нийт болон мэргэжлийн бүлэгт хандсан байхаас биш хүүхдэд, эрэгтэйчүүдэд, өндөр настнуудад, хөдөөгийнхөнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нь туйлын ховор байна.

Өдөр тутмын сонинуудад эрүүл мэндийн сэдвээр бичих хүсэл сонирхолтой, тодорхой хэмжээнд энэ чиглэлээр бичиж гаршсан цөөнгүй сэтгүүлч байгаа нь сайшаалтай. Гэвч тэд нийгэм соёл гэхчилэн өөр албанд харьяалагдаж, цаг зав маш бага байдгаас шалтгаалан эрүүл мэндийн сэдвээр түлхүү бичих, даацтай нийтлэл гаргах нөхцөл боломж нь хязгаарлагдмал байдаг аж. Судалгаанаас үзэхэд сэтгүүлчид эрүүл мэндтэй холбоотой хувийн нууцад халдах зэрэг мэргэжлийн ноцтой ёс зүйн алдаа гаргадаггүй ба эх сурвалжийн хувьд хангалттай, мэдээллийн тэнцвэрт байдлыг тодорхой хэмжээгээр хадгалсан байна. Эрэн сурвалжилсан, хаалттай нуугдмал зүйлийг илчилсэн, эсвэл шинжлэх ухаан танин мэдэхүйн хялбаршуулсан, тайлбарласан бичлэг бага байна. Энэ сэдвээр бичдэг сэтгүүлчид мэргэжлийн чиглэлийн мэдлэг мэдээлэл дутмаг байгааг эс тооцвол ур чадварын хувьд муугүй ч шинэ сэдэл, идэвх санаачилга бас чамлалттай байна.

Ишлэл

¹ Зулькафиль М. Сэтгүүл зүй ба "дөрөв дэх засаглал" // "Сэтгүүл зүй" эрдэм шинжилгээний бичиг, 2004, №21, х. 8.

² Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн ур чадварын асуудал: уламжлал ба шинэчлэл. УБ., х. 206-207.

³ Отгонцэцэг С. 2006. Эрүүл мэндийн сэтгүүл зүйн үндэс. УБ., х. 29.

⁴ Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. (Орч. Б.Агар нар). УБ., х. 33.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн ур чадварын асуудал: уламжлал ба шинэчлэл. УБ.

2. Зулькафиль М. 2007. Орчин үеийн Монголын сэтгүүл зүй. УБ.
3. Зулькафиль М. 2006. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал (Цуврал №3). УБ.
4. Отгонцэцэг С. 2006. Эрүүл мэндийн сэтгүүл зүйн үндэс. УБ.
5. Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. (Орч. Б.Агар нар). УБ.
6. Поттер Д. 2004. Бие даасан сэтгүүл зүйн гарын авлага. УБ.
7. 2009. МХХ-гийн мониторингийн судалгаа. Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр. УБ.
8. 2006. МХХ-гийн судалгааны тайлан. Эрүүл мэндийн сэтгүүл зүй. УБ.

Summary

In our research paper, we intended to give brief explanation about what is health

journalism and to describe how often health articles have been published in Mongolian daily newspapers. Besides, we tried to explore specific methods and ways of getting sources for publishing health articles. During our research work we found out that daily newspapers don't actually provide enough space for health articles. The published articles were usually about medical science, healthy life style, treatment without medicine, healthy food and some benefits of doing the exercise. The articles didn't explain about how preventing from some unexpected risks, and about new methods. Also there is a lack of information for children, elderly people, residents who are living in remote provinces and physically disabled people. In conclusion there required improvement of quality of articles and change of writing style journalist's.